МЭДЭЭ · 2020 оны 11-р сарын 12

Ш.БААСАНДОРЖ:ЕВРОПЫН ПРОКУРОРЫН ГАЗАР 2020 ОНД ҮҮДЭЭ НЭЭНЭ





Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь Сум дундын прокурорын газрын ерөнхий прокурор, докторант Ш.Баасандорж

Монгол Улсад Прокурорын байгууллага үүсэж байгууллагдсаны түүхт 90 жилийн ой тохиож буй энэ оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн Европын прокурорын газар нь үүд хаалгаа нээж, чиг үүргээ гүйцэтгэж эхлэхэд бэлэн болжээ. Энэхүү он цагийн давхцал нь доктор С.Дуламын “Монгол бэлгэдэл зүй”-н тооны бэлгэдэл, цагийн бэлгэдэл зүйн үүднээс үзвэл санаандгүй давхцал биш гэлтэй.

Түүх сөхвөл, Англид 1243 онд “ерөнхий атторней” /зөвхөн эх орноосоо урвах гэмт хэргийг хааны нэрийн өмнөөс яллах эрх бүхий/ гэсэн албан тушаалтан бий болж, түүний ажлын алба нь 1327 онд байгуулагдаж байсан бол Францад 1303 онд “хааны хүмүүс” /эх газрын прокурор/ гэсэн албан тушаалтан бий болж, тэд хаан, нийгэм, нийтийн ашиг сонирхлын өмнөөс мөрдөн шалгах ажиллагаа явуулах, яллах чиг үүрэгтэйгээр ажиллаж, тухайн цаг үеийн өрсөлдөгч 2 гол улс нь өөр өөрсдийн эрх зүйдээ тохирох прокурортой болсон билээ. Харин “хааны хүмүүс” төд удалгүй “хааны прокурор” гэсэн нэршилтэй болж, дэлхийн улс орны прокурорын байгууллагуудын анхдагч жишиг болсон гэдэг.

Нийтлэлч Баабар “Коллеж ба Их сургуулийн ялгаа” нийтлэлдээ “...Дэлхийн хамгийн ууган их сургуулиудын нэг нь Парис дахь Сорбоны их сургууль юм. Тэнд англичууд ирж сурдаг байж. Гэтэл Англи, Франц хоёр муудан дайн тулалдаандаа хүрсэн учир англичууд өөрийн нутаг дээр анхны их сургуулиа байгуулжээ. Энэ бол XII зууны эх буюу Чингисээс зуугаад жилийн өмнөх явдал. Ингээд соёл шинжлэх ухааны хоёр том төвийн хоорондх жишиг, нэршлээс авахуулаад үзэл баримтлалын зөрөө гарч ирсэн аж...Гэвч мөнхийн өрсөлдөгч англичуудаас дутахгүйн тулд тэд өөрийн дэг сургуулийг шинжлэх ухаан, соёл урлаг, аж үйлдвэр, эдийн засгийн бүхий л салбарт буй болгосон юм. Чухам энэ зөрөөнөөс болж Францаас гаралтай “эх газрын”, Англиас үүсэлтэй “англо-саксоны” гэсэн хоорондоо ялгаатай жишиг стандарт буй болжээ. Хуулийн бүхий л жишиг түүнээ дагасан олон стандарт энэ зөрүүг улам баталгаажуулна. Анх Францад тогтоосон Си систем буюу Олон улсын нэгжийн системийг англо-саксончууд аваагүй...Иймдээ бид фут, паунд, фаранхайтын хэм, унци, бушель, галоныг өөрийн метрийн системд хөрвүүлж ойлгох гэж үйлээ эдэлдэг. Гэхдээ англо-саксончууд шинжлэх ухааны салбарт мм, литр, кг, цельсын хэм гэх мэтээр Олон улсын нэгжийн системийг аргагүй хэрэглэдэг л дээ...Гэхдээ орчин үеийн ертөнц нэгдсэн нэг жишиг рүү орж буй юм. Харин англо-саксон болон эх газрын тогтолцоо

зэрэгцэн оршсоор байна. Германчууд Францаас, Оросууд Германаас, Монголчууд Оросоос дамжуулан хэрэглэсээр ерөнхийдөө Монголд эх газрын тогтолцоо бүх салбарт өөриймшсөн юм. Гэтэл 1990 оноос англо-саксоны систем салбар болгонд зэрэгцэн орж иржээ. Зурагтын дэлгэцийн хэмжээг инчээр ярьдаг нь ч дэлхий даяар тогтсон зүйл гэж бодъё. Гэтэл хуульд энэ хоёр өөр тогтолцоо зэрэгцэн орж ирсэн нь маш их будлиан үүсгэж байгаа юм...” гэж бичсэн нь нэгийг хэлэх бөгөөд энэ зөрөө, ялгаа нь прокурорын байгууллагын тогтолцоо, прокурорын чиг үүргээс ч харагдана.

Европын Холбооноос Англи гарч буй энэ цаг мөчид уг холбооны 22 улс орнууд эх газрын эрх зүйн тогтолцоон дахь прокурорын байгууллагын адил Европын Прокурорын газрыг байгуулж, өөрсдийн улс орныхоо дотоодын холбогдох хууль тогтоомжуудад, ялангуяа эрүүгийн процессын хуульдаа энэ байгууллагатай холбоотой нэмэлт, өөрчлөлтийг ч аль хэдийн хийж, прокуроруудаа хүртэл томилоод амжжээ. Европын Холбооны 27 улсын 5 улс нь дуртай үедээ энэ байгууллагын үйл ажиллагаанд нэгдэн орох боломжтой гэнэ.

Европын Прокурорын газрын ерөнхий прокуророор Румын Улсын иргэн Лаура Кодруца Кёвеси /Laura Codruta Kövesi/ томилогдсон байна. Энэ хатагтайн талаар монголчууд хэвлэл, мэдээллээсээ уншиж, хэдийн танил болсон байх. Танил болж амжаагүй нэгэн нь “Румын Улсын Ерөнхийлөгч тус улсын Авлигатай тэмцэх байгууллагын даргыг огцруулах саналд татгалзсан хариу өгчээ”, “Ахыгаа шорон руу илгээхээс ажлаа эхэлсэн Румын улсын үндэсний баатар АТГ-ын дарга Лаура Кодруца Ковеши”, “Бухарест, Засгийн газрын эсрэг эсэргүүцлийн үеэр 450 хүн бэртжээ” гэсэн гарчгийнх нь текстээр гүүглээр хайж, түүний талаар эх хэлээрээ уншин, мөн “Laura Codruta Kövesi” гэсэн түүний нэрээр хайж, өөрсдийн мэдэх гадаад хэл дээр энэ хүний талаар мэдээлэл авч болохоор байна.

Прокурор, хатагтайн талаар эх хэлээрээ аль зэрэг мэдээ, мэдээлэл байна гэж гүүгл хайлтын системээр хайсны адил миний бие түүний толгойлох гэж буй байгууллагынх нь талаар монголоор гүүглэдэж үзлээ.

Тэгтэл, “Европын холбооны орнууд европын нэгдсэн прокурорын газар байгуулахаар шийджээ” гэсэн гарчигтай “О.Барс, Эх сурвалж: Монцамэ” гэсэн мэдээ, мэдээлэл “uls.mn” сайтад тавигдсан нь гүүгл хайлтын системд байна.

Үүнээс гадна “prokuror.mn” сайтад “Ром-Германы Эрүүгийн процесс” номынхоо талаар өгсөн ярилцлагын “Та номондоо Европын прокурорын газрын тухай бичсэн байх юм. Энэ ямар учиртай юм бэ?” гэсэн асуултад “Европын прокурорын газар нь дэлхий нийтийн прокурорын байгууллагын хөгжлийн цаашдын чиг хандлагыг тодорхойлно гэж боддог. Европын холбоо, холбооныхоо санхүүгийн ашиг сонирхлоо хэрхэн хамгаалах, Европын төсөв, санхүү, сан, фонд, хөрөнгө мөнгөө хэрхэн хамгаалах, зарцуулалтад нь хэрхэн хяналт тавих, зарцуулалтын явцад гэмт хэргийн шинжтэй үйлдэл байгаа эсэх, ашиглан шамшигдуулсан эсэх, авлига, албан тушаалтны гэмт үйлдэл байгаа эсэх, Европын холбооны татвараас зайлсхийж байгаа эсэх зэрэг өргөн хүрээнд хянах, холбооны санхүүгийн ашиг сонирхолд

харш, халдсан хууль бус үйл ажиллагаатай тэмцэх зорилготой, мөрдөн шалгах эрх хэмжээтэй прокурорын газрыг байгуулж байна. Европын нэгдсэн прокурорын газар Франц, Герман улсын хамтын хүчтэй шаардлагын үндсэн дээр байгуулагдаж байна. Энэ байгууллагын анхны үзэл санаа, баримтлал, онол нь Францын хуульч Мирей Делмас Марти-гаас эхтэй юм. Хэрвээ манайд прокурорын байгууллагадаа ийм эрх мэдэл өгвөл юу болох вэ? Та төсөөлдөө? Прокурорын ерөнхий хяналт сэргэж байна гээд прокурор төсөв, санхүү хянах нь байна, бүүр зарцуулалтыг шалгах нь байна гээд...,шуугих байх. Одоогоор манай улсад энэ байгууллагын талаар мэдэж, ярьж, судалж байгаа хүн алга. Тиймээс оруулсан хэрэг.” гэж хариулж байсан ярилцлага маань гарч ирж байх юм.

Европын холбоо юуны учир энэ байгууллагыг байгуулах болсон учир шалтгааны талаар европын улс орны хэвлэл, мэдээллийн байгууллагууд, мэргэжилтнүүд янз бүрээр л бичиж байна. Энэ талаар товчлон тоймловол, Европын холбооны төсөв, санхүүд, сан, фондод их хэмжээний ашиглан шамшигдуулах явдал гарсаар байгаа тул дагнасан, хил хязгаараар баригдахгүй ажиллах прокурорын газрыг байгуулах зайлшгүй хэрэгцээ, шаардлагатай, Европын холбооны улс орнууд хил дамнан үйлдэгдсэн санхүү, эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх, шуурхай шалган шийдвэрлэх, илрүүлэх боломж, чадавх нь хязгаарлагдмал, холбооны улс орны хуулийн байгууллагууд өөрсдийн хууль тогтоомж, хил, гаалиар хязгаарлагдаад энэ төрлийн гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэж чадахгүй байгаа, зарим улс орнууд цагаан захтны гэмт хэрэгтэй тэмцэх хүсэл, сонирхол бага байгаа, тэмцэх хууль, хүн хүчний нөөц боломж, бололцоо, чадавх, чадамж нь харилцан адилгүй ялгаатай, тухайн улс орны эрүүгийн процессын хуулийн зарим дутагдалтай, доголдолтой, хийдэлтэй эрх зүйн зохицуулалт, механизм, төр засгийн бодлого, ялангуяа энэ төрлийн эрүүгийн бодлогын дутмаг байдал, хэлний бэрхшээл буюу барьер зэрэг олон учир шалтгааныг дурдан бичиж байна.

Түүгээр тогтохгүй хуульч эрдэмтэн, судлаачид ч гэсэн энэ талаар ихээхэн бичиж, уулзалт, семинар, зөвлөгөөнөө хийж, эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлээ танилцуулж, харилцан үзэл баримтлал, байр сууриа солилцож байна. Энэ чиглэлээр бичсэн, хэлэлцсэн зарим эрдэмтэн, судлаачдын эрдэм шинжилгээ, судалгааны өгүүлэл, нийтлэлийг ч Парисын их сургууль, Парисын харьцуулсан эрх зүйн хүрээлэн, Европын эрүүгийн эрх зүйн судалгааны ассоциац, Харьцуулсан хууль тогтоомжийн нийгэмлэг зэрэг байгууллагуудаас “Le contrôle judiciaire du Parquet européen nécessité, modèles, enjeux” гэсэн нэрээр гаргасан эмхтгэл ч байх бөгөөд уг бүтээлийг уншиж танилцан, Европын прокурорын газар гэсэн байгууллагыг байгуулах болсон учир шалтгаан, үзэл баримтлал, үзэл санааг нь бүрэн гүйцэд ойлгож чадна.

Европын Прокурорын газар нь Европын холбооны төсвийг ашиглан шамшигдуулах, луйвар, авлига, хил, гаалиар дамжуулан нэмэгдсэн өртгийн албан татвараас зайлсхийх, татвараас зугтаах /мөнгө угаах/ зэрэг гэмт хэргийг мөрдөн байцаах, яллах, шүүхэд шилжүүлэх бүрэн эрхтэй Европын холбооны хараат бус, төвлөрсөн бус прокурорын газар юм /The European Public Prosecutor’s Office will be an independent and decentralised prosecution

office of the European Union, with the competence to investigate, prosecute and bring to judgment crimes against the EU budget, such as fraud, corruption or serious cross-border VAT fraud/ гэж Европын комиссын “ec.europa.eu” сайтад бичжээ.

Прокурор нь өөрөө мөрдөн шалгах ажиллагаа буюу мөрдөн байцаалт бие даан явуулдаг нь социалист эрх зүйн тогтолцоон дахь онцлог биш бөгөөд өнөөгийн Европын холбоо бус Европын зөвлөлийн 45 улсын 35 улс орны прокурорын байгууллага мөрдөн шалгах ажиллагаа буюу мөрдөн байцаалт явуулах эрх хэмжээтэй гэж Европын зөвлөлөөс гаргасан “Systèmes judiciaires européens:2016” товхимолд бичсэн байна.

Европын түүхэнд, прокурор XIII зуунаас мөрдөн шалгах ажиллагаа буюу мөрдөн байцаалт явуулж эхэлсэн бол цагдаа XIX зуунаас л эхэлж явуулсан байдаг.

Европын прокурорын газрыг байгуулах болсон зорилго, учир шалтгаан, энэ байгууллагын чиг үүрэг, цар хүрээ, онцлог, холбогдох хууль тогтоомжууд зэргийг нь судлан үзэж, энэ хэрээр Европын улс орнууд санхүү, эдийн засаг, мөнгө угаах, татвараас зайлсхийх, авлига, албан тушаалын гэмт хэргийг мөрдөн шалгах, яллах чиг үүрэг бүхий дагнасан, мэргэшсэн прокурорын газрыг байгуулж байгааг, энэ чиг үүрэг бүхий прокурорын газруудтай улс орнууд нь улам бэхжүүлж, чадавхжуулж байгааг мэдэж, одоогийн Засгийн газар хэрэгжүүлж буй эрх зүйн шинэтгэлдээ зарим туршлагаас нь нутагшуулж, шүүхийн шинэчлэлийг дан ганц шүүхээр авч үздэгээ болих цаг ирэх биз ээ.

Тэгснээр, цаашид Монгол Улс “Саарал жагсаалт”-д дахин орох эрсдэл учрахгүй байх магадлалтай бөгөөд тэр учир нь саарал жагсаалтыг гаргаж буй улс орнууд нь энд дурдсан арга замаар л энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэж байгаад байгаа билээ.

Европын холбоо Европын прокурорын газрыг байгуулж байгаагаа, мөн гишүүн орнууд нь ч тэр шүүх дэх шинэчлэл, реформ хийлээ гэж үзэж байна.